

**Нэр томъёоны стандарт дахь зарим нэр томъёог үг бүтэх ёс,
утгын талаас авч үзэх нь**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Хөөдөөгийн ГЭНДЭНПИЛ*

*Монгол Улс, Улаанбаатар, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Хэрэглээний хэл шинжлэлийн салбар*

Received: May 15, 2024

Revised: October 28, 2024

Accepted: November 07, 2024

Хураангуй: Энэхүү өгүүлэлд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран бүрдүүлсэн 85 стандартын 10387 нэр томъёо, тодорхойлолт бүхий хөмрөгт тулгуурлан, нийлэмж нэр томъёо, ойролцоо утгатай нэр томъёог задлан шинжлэв. Нийлэмж нэр томъёог хэв шинж, бүрэлдэхүүн, давтамжийн талаас бус тодотгох үүргээр хэрэглэгдэж буй “-н” нөхцөлтэй цөөн нэр томъёогоор жишээлэн, нийлмэл үгийн бүтцийн үүднээс ажиглав. Мөн ойролцоо утгатай нэр томъёог тухайн илэрхийлж буй ухагдахуун, тодорхойлолттой нь харьцуулж үзлээ. Нэр томъёоны стандартын хөмрөг дэх ойролцоо утгатай нэр томъёоны ухагдахуун, тодорхойлолтыг задлан шинжлэхэд нэг ухагдахууныг давтан илэрхийлсэн зүйл ажиглагдаж байна. Мөн дээд ухагдахуун нь ижил, зэрэгцээ ухагдахууныг илэрхийлсэн ойролцоо утгатай нийлэмж нэр томъёог энгийн нэр томъёо (дан үг)-оор оноох тухай жишээ татан тайлбарлалаа.

Түлхүүр үг: нэр томъёоны стандарт, нэр томъёо, ухагдахуун, үгийн сан, үг бүтэх ёс, зэрэгцээ ухагдахуун, ойролцоо утга, ойролцоо утгатай нэр томъёо

* © Х.Гэндэнпил, 2024

Email: gendenpil_kh@mas.ac.mn, <https://orcid.org/0009-0008-2748-9789>

Considering some terms in the terminology standard from the perspective of word formation and meaning

GENDENPIL Khuuduu

Department of Applied Linguistics, the Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article examines compound terms and terms with synonymous meanings, based on the corpus with 10,387 terms and definitions from 85 standards compiled by the Institute of Language and Literature at the Mongolian Academy of Sciences and the Office of the National Council for Language Policy. The study investigates compound terms from the perspective of word structure, focusing on examples with the suffix “-n” for clarification, rather than analyzing their type, composition, or frequency. Additionally, terms with synonymous meanings are compared to the concepts and definitions they represent. The analysis shows that a single concept is often expressed multiple times across the terminology standards. Furthermore, compound terms with synonymous meanings, representing either coordinate concepts or similar superordinate concepts, can be simplified into simpler terms in some examples.

Keywords: terminology standard, terms, concept, lexical, word formation, coordinate concept, synonym, synonym terms

1. Удиртгал

Мэргэжлийн салбар юм уу судлагдахуунд хамаарах ухагдахуун ба түүний илэрхийллийн (нэрлэлтийн) цогцыг нэр томъёо судлал гэнэ (ISO 1087: 2019). Ухагдахуун гэдэг нь онцлог шинжийн хослолоор бий болсон мэдлэгийн нэгж, харин нэрлэлт нь судлагдахуун юм уу мэргэжлийн салбарт хамаарах ухагдахууны илэрхийлэл юм. (ISO 1087: 2019). “Мэргэжлийн салбарын ухагдахууныг илэрхийлэх нэг болон нэгээс олон үгээс бүрдсэн үгийн сангийн нэгжийг нэр томъёо гэнэ”. (Брүнд де Бессе¹, Нквенти-Азе², Сэйжир³, 1997: 152). “Нэр томъёо нь салбарын мэдлэгийг ухагдахууны түвшинд илэрхийлэх, салбарын тусгай мэдээлэл, мэдлэгт нэвтрэх хэрэгсэл болдог тул стандартчиллын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үндэсний стандарт уу эсвэл олон улсын стандарт уу гэдгээс үл хамааран нэр томъёо нь бүх стандартын чухал махбод болдог” (Мөнхцэцэг, 2022: 158). Тодорхойлолт, тайлбар, тэмдэглэл, зураг дүрслэл, жишээ бүхий нэр томъёоны холбогдолт стандартыг нэр томъёоны стандарт (ISO/IEC Guide 2: 2004, 5.2) гэнэ. Тусгай стандартад нийцсэн нэр томъёог батлах үйл явцыг нэр томъёоны стандартчилал (<https://www.gov.wales/bydtermcymru>) гэдэг. Нэр томъёоны стандартын үндсэн шалгуур нь:

¹ Brund de Besse

² Blaise Nkwenti-Azeh

³ Juan C Sager

- Нэр томьёо нь үг зүйн хувьд зөв хэлбэржсэн байх;
- Илэрхийлж буй ухагдахууны онцлогийг аль болох тусгахыг эрмэлзэх;
- Товч тодорхой байх;
- Бусад хэлбэрийг бүтээх чадамжтай байх;

Дан ухагдахууныг зөвхөн нэг нэр томьёогоор илэрхийлэх (<https://www.gov.wales/bydtermcymru>) зэрэг юм.

Бид энэхүү өгүүлэлд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран бүрдүүлсэн 85 стандартын 10387 нэр томьёо, тодорхойлолт бүхий Нэр томьёоны стандартын хөмрөг /цаашид НТСХ гэж товчилно/-т тулгуурлан, нэр томьёо бүтэх зарим арга, нэр томьёоны нэрлэлт болон ойролцоо утгатай нэр томьёог авч үзнэ.

2. Судалгааны арга зүй

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран, Нэр томьёоны стандартын хөмрөг /цаашид НТСХ гэж товчилно/-ийг бүрдүүлсэн билээ. Тус хөмрөг *Худалдааны үйлчилгээ*, *Худалдааны газрын ангилал нэр томьёо* (MNS 6506: 2015), *Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо* (MNS 0639: 2016), *Байгаль хамгаалал, Газар, газар ашиглалтын нэр томьёо* (MNS 3473: 1983), *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа*, *Эрүүл ахуйн нэр томьёо* (MNS 4967: 2000), *Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Цахилгааны аюулгүй ажиллагаа* (MNS 5151: 2002) зэрэг 85 стандартын 10387 нэр томьёо, тодорхойлолтоос бүрдэнэ. Энэхүү хөмрөг дэх тодотгох үүргээр хэрэглэгдэж буй “н” үндэстэй нэр томьёог бүтцийн үүднээс задлан шинжлэв. Мөн ойролцоо утгатай нэр томьёоны ухагдахуун, нэрлэлтийг авч үзлээ.


3. Нэр томьёоны стандарт дахь зарим нэр томьёог үг бүтэх ёсны үүднээс авч үзэх нь

“Монгол хэлний үг бүтэх аргыг ашиглан, шинэ нэр томьёо бүтээх нь нэр томьёо оноон тогтооход баримталж байгаа үндсэн зарчмын нэг юм” (Догсүрэн, 1988: 12). Үүнд *дагаврын аргаар хэлбэржүүлэх, дан үгийг нийлэмж үг, нийлмэл үг болгох, үг хураах* зэрэг үг бүтээх арга хамаарна. (Догсүрэн, 1988: 12). Орчин цагийн монгол хэлнээ *дагаврын* болон *үг нийлэх арга* нь үг бүтэх үндсэн арга. Харин *үг товчлох* болон *авиа сэлгэх* нь туслах арга юм (Өнөрбаян, 2004: 27-76). Нэгээс илүү үг ба үгийн сангийн нэгжээс бүрдсэн нэр томьёог *нийлэмж нэр томьёо* (complex term) гэдэг (ISO 1087: 2019). Нийлэмж үг хэмээх ойлголт нь хоёроос дээш үгээс бүтсэн хоршоо үг, холбоо, нийлмэл үгийг бүтдийг багтаасан ойлголт бөгөөд нэр томьёо бүтээхэд нийлэмж үгийн төрөл зүйлүүд цөм оролцоно. (Шагдарсүрэн ба бус, 2022: 99). “Дан үгээс илүү нийлэмж нэр томьёоны нэрлэх

чадвар илүү бөгөөд дан үгээр нэг л ухагдахуун тэмдэглэж чаддаг бол дахин нэг үг нэмэгдсэнээр өнгө, шинж, хэлбэр зэргийг тодруулан илүү тодорхой ойлголт бий болгох боломжтой тул нарийвчлан нэрлэдэг” (Шагдарсүрэн ба бус, 2022: 99). “Нийлэмж үгийг үг бүтэх ёсны үүднээс үзвэл, задлаг хам бүтэц бөгөөд энэ нь хэлний нийлэмж чанар хэмээх ойлголттой салшгүй холбоотой” (Гэрэлмаа, 2020: 147). Энэ хэсэгт НТСХ-т буй үг нийлэх аргаар үүссэн зарим нэр томъёог үг бүтэх аргын талаас авч үзье.

НТСХ-т галоидын нүүрс устөрөгчтэй гал унтраах бодисын цэнэгтэй гал унтраагуурыг *нунтган гал унтраагуур* (MNS 0639: 2016); тэжээлийн ус буюу хувирсан усаар шүршиж уурын температурыг бууруулж, тохируулах уур хөргүүрийг *шүршүүрэн уур хөргүүр* (MNS 5086: 2001); цагариган завсартай үлээх гаргалга бүхий шатаагуурыг *цагариган шатаагуур* (MNS 5086: 2001); түрийт ултай нь шурган утсаар холбосон улагаатай гутлыг *шурган улагаатай гутал* (MNS 0096: 1982); цайвар хайрст хоёр үе давхаргаас бүрдсэн 30 мм хүртэл дундаж нарийнтай ноосон ширхгийг *ноолуур / ноолууран ширхэг* (MNS 3362: 1982); шилжүүлэх механизмаар тоноглоогүй ба чирүүлж шилждэг краныг *чиргүүлэн кран* (MNS ISO 4306-1: 2014); гол бүтээц (5.1.2) нь болох нэг буюу түүнээс дээш аркаас (5.1.8) тогтох гүүр (3.3.19)-ийг *аркан гүүр, нуман гүүр* (MNS ISO 6701-1:2010); хөдөлгөөнгүй ба түүнтэй харьцангуйгаар төвийн шилжилттэйгээр эргэж байгаа хөдөлгөөнтэй хэсгээс бүрдсэн шахалтаар буталдаг төхөөрөмжийг *конусан бутлуур* (MNS ISO 11375: 2000); хоёр хэмжээст топологийн эх биет (B.490)-ийг *нүүрэн хэсэг* (MNS ISO/TS 19104: 2012); дотоод шингэний даралт нь таган жийрэг эсвэл даралтан тээг бөгжин дээрх шахалтын ачааллыг ихэсгэж буй тэрхүү хэсэгт буй их биеийн таган холбоос (5.5.30)-ыг *даралтад тээгэн холбоос* (MNS ISO 6701-1: 2010); барилгын талбайд материалыг цэгэн хэлбэрээр оёх төхөөрөмжийг *цэгэн гагнуурын төхөөрөмж* (MNS ISO 11375: 2000); түрийний эд ангийг нийтэд нь буюу зонхилох хэсгийг резинээр хийсэн гутлыг *резинэн гутал* (MNS 0096: 1982); зоргодох хутгыг зээрэнцэг дээр бэхэлсэн суурь машиныг *зээрэнцгэн хутгатай зоргодослох суурь машин* (MNS 0121: 1988); диск болон колодоктой тоормосыг *дискэн тоормос* (MNS ISO 4306-1: 2010); бие даан өөрөө хөдөлгөөн хийдэггүй бөгөөд зөвхөн тээврийн хэрэгслээр чирүүлж ажил гүйцэтгэдэг хэрэгслийг *чиргүүлэн индүү* (MNS ISO 6165: 2006); программ болон түүний хэсэг, мөн программын биелэлтэд шаардагдах өгөгдөл буюу түүний хэсэгт ерөнхий хадгалуур ашиглах чадвартай компьютерыг *цифрэн компьютер* (MNS ISO 2392-1: 1999) зэрэг нийлэмж үгээр нэрлэжээ. Эртний монгол хэлнээ “-н” үндэстэй байсан үгсийг тодотгогчийн үүргээр хэрэглэх тохиолдолд уг “-н” гийгүүлэгч сэргэх үзэгдэл буй. *Нунтган гал унтраагуур, шүршүүрэн уур хөргүүр, цагариган шатаагуур, шурган улагаатай гутал, ноолууран ширхэг, нүүрэн хэсэг, тээгэн холбоос, чиргүүлэн кран, аркан гүүр, конусан бутлуур* зэрэг нь үүний аналогior үүссэн хэлний буруу үзэгдлийн жишээ юм.

Дээр дурдсан *нунтаг* (Mo. nuntuγ), *шүршүүр* (Mo. šürsigür), *цагариг* (Mo. čaγariγ), *шураг* (Mo. siruγ), *ноолуур* (Mo. noluur), *чиргүүл* (Mo. čirgeül), *нүүр* (Mo. niγur), *тээг* (Mo. tegeg), *цэг* (Mo. čeg), *зээрэнцэг* (Mo. jegerenčeg) зэрэг үг нь монгол бичгийн хэлнээ “-н” үндэсгүй юм. Энэ үзэгдэл уугуул үгээс гадна *конус*, *резин*, *диск*, *цифр* зэрэг гийгүүлэгчээр төгссөн гадаад үгэнд ч мөн тохиолдож байна. НТСХ-т буй буруу хэлбэржсэн нэр томьёог загварчлан үзүүлье.



Зураг 1. НТСХ-ийн буруу хэлбэржсэн нийлэмж нэр томьёо

Монгол бичгийн хэлэнд дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн бүх үг энэхүү нууц хэмээгдэх тогтворгүй “-н” бүтээврийг огт авдаггүй ёс журамтай (Пүрэвжав, 2022: 168). Иймд дээр дурдсан (Зураг 2) нэр томьёог тодотгогч “-н” үндсээр хэлбэржүүлэлгүй *шураг уллагаатай гутал*, *зээрэнцэг хутгатай зоргодослох суурь машин*, *тээг холбоос*, *нүүр хэсэг*, *нунтаг гал унтраагуур*, *цагариг шатаагуур* хэмээн нэр томьёо оноох бүрэн боломжтой юм. Түүнчлэн *цэгийн гагнуурын төхөөрөмж*, *чиргүүлийн кран*, *шүршүүрийн уур хөргүүр*, *ноолуурын ширхэг* хэмээн хэлбэржүүлэх нь нийлмэл үгийн бүтцийн хувьд тохирно. Энэ нь нэр томьёоны стандартын үг зүйн хувьд зөв хэлбэржсэн байх; товч тодорхой байх зэрэг шалгуурт бүрэн тохирно.

“Монгол бичигт гийгүүлэгчээр төгсдөг нэр язгуур, үндсүүд ярианы хэлэнд “н” үндэстэй болох нь бас элбэг болов. Тодотгох үүрэгтэй хэрэглэж буй тэдгээр язгуур, үндсийг ажиглавал, нэг хэсэг нь буруу хэвшсэн тохиолдол юм” (Соронзон, 2021: 7). Иймд *шурган уллагаатай гутал*, *ноолууран ширхэг*, *зээрэнцгэн хутгатай зоргодослох суурь машин*, *тээгэн холбоос*, *нүүрэн хэсэг*, *нунтган гал унтраагуур*, *цагариган шатаагуур* зэрэг нь гийгүүлэгчээр төгссөн нэр язгуур “н” үндэстэй болж, буруу хэвшсэн үзэгдэл юм. Энэ тухайд М.Саруул-Эрдэнэ сонирхолтой санал дэвшүүлсэн байдаг. Тэрээр “хүрлээр хийсэн зэвсгийг хүрлэн зэвсэг гэдэггүй, хүрэл зэвсэг гэдэг, мөн хөргөн зураг биш хөрөг зураг

гэдгийн адилаар бол таргаар хийсэн бялууг *тараг бялуу* л гэж хэлэх ёстой юм. Гэтэл хэлний амьд хэрэглээ өөрийг хэлээд буй (Саруул-Эрдэнэ, 2015: 156). Түүнчлэн хэл зүйн идэвхтэй дүрэм бага давтамжтай дүрмээ өөртөө татан ижилсүүлэх ёсыг “аналоги” гэнэ. Цагийн явцад жинхэнэ зөв хэлбэр нь мартагдаад, *аналоги** дүрэм болж хэвших нь олонтоо (Саруул-Эрдэнэ, 2015: 107).

* Хамгийн түгээмэл хэрэглэгддэг дүрмийн бус хэлбэр нь дүрмийн хэлбэрээ хувиргадаг. Тухайлбал, өвөг англи хэлний *brethren* “ах дүүс” хэмээх дүрмийн бус үг бусад олон тооны хэлбэрийн аналогior *brothers* “ах дүүс” болж хувирчээ (Keith Brown, Jim Miller, 2013: 24).

Иймд *тарган цавуу, цэцгэн бууз, гэрлэн дохио, тавган антенн* зэрэг нь хэлний хөгжлийн явцад бүрэлдэн буй болсон шинэ үзэгдэл, зүй тогтол юм. Энэхүү үзэгдэл, зүй тогтлын нөлөөгөөр нийлмэл үгийн бүтэц дэх гийгүүлэгчээр төгссөн бүхий л үгийг “-н” үндсээр хэлбэржүүлэх нь буруу билээ.

Түүнчлэн “ихэвчлэн байгалийн кварц элс буюу шилийг хайлуулж гаргаж авдаг эрдэс хөвөнг *шилэн хөвөн* (MNS ISO 9229: 2010); тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын хөдөлгөөнийг зохицуулах хэрэгсэл бөгөөд төмөр замын гэрлэн дохио нь зоомол шон дээр суулгагдсан тольдуур дохионы хэлбэртэйг *гэрлэн дохио*” (MNS 6387-1: 2013); тухайн гурвалжны оройг дайрч гарсан, өөр гурвалжны оройг дотор тал (B.262)-даа эс агуулсан тийм гурвалжнуудаас үүсэх сүлжээ (B.322)-г *шугаман триангуляц* (MNS ISO/TS 19104: 2012) гэж оноосон нь тодотгох үүрэгтэй “-н” гийгүүлэгчээр хэлбэржиж, хэлний хэрэглээнд нэгэнтээ хэвшин тогтсон (тарган цавуу, цэцгэн бууз, тавган антенн г.м) үзэгдэл юм. Монгол бичгийн хэлнээ *шил* (Mo. sil), *гэрэл* (Mo. gerel), *шугам* (Mo. šuyum) хэмээн гийгүүлэгчээр төгссөн хэдий ч хэлний амьд хэрэглээнд аналогior *шилэн хөвөн, гэрлэн дохио, шугаман триангуляц* (*шугаман солбицлын тогтолцоо, шугаман байршлын тогтолцоо, шугаман суурь тогтолцоо, шугаман суурьт тогтолцоо* г.м) гэж хэвшин тогтжээ. Энэ мэтчилэн НТСХ дэх нэр томъёог бүтэц, нэрлэлтийн үүднээс жигдлэх шаардлагатай байна. Харин одоо НТСХ дэх ойролцоо утгатай нэр томъёог ухагдахууны тогтолцоо, нэрлэлтийн талаас авч үзье.

4. Нэр томъёоны стандарт дахь ойролцоо утгатай нэр томъёо

Нэр томъёоны олон улсын стандартад “хэлэн дэх ижил ухагдахууныг илэрхийлэх нэрлэлт хоорондын харьцааг ойролцоо нэр (synonym) гэж тодорхойлжээ (ISO 1087: 2019(E)). Мөн ойролцоо нэр (synonym / equivalent) нь ижил ухагдахууны хүрээ болон ижил харьцаанд буй өөр хоорондоо ялгаатай нэр томъёо юм уу үгийн хоорондох парадигм харьцаа юм. (Brund de Besse, Blaise Nkwenti-Azeh Juan C Sager, 1997: 151). Судлаачид ойролцоо нэрийг дүйцэлтэй адил гэж үзжээ. Харин олон улсын стандартад “хоёр өөр хэлнээ ижил ухагдахууныг илэрхийлэх нэрлэлт хоорондын харьцааг дүйцэл (equivalent) (ISO 1087: 2019(E)) гэж тодорхойлсон байдаг.

“Нэг хэлэн дэх ижил ухагдахууныг нэрлэсэн үгс хоорондын харьцаа нь ойролцоо нэр юм. Адилхан, эсвэл тун ойролцоо утгатай хоорондоо авиалбар зүйн хувьд ялгаатай үгсийг ойролцоо нэр гэнэ” (Saeed, 2009: 65). Н.Мөнхцэцэг (2021) Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй 380 хуулиар хөмрөг бүрдүүлэн, *гэм хор, хохирол, хор уршиг* хэмээх ойролцоо нэр томьёоны ухагдахууны тогтолцоо, утгын ялгааг авч үзсэн байна. Тэрээр ойролцоо утгатай үгс хэлний үгийн санд түгээмэл байдаг боловч мэргэжлийн үгийн сангийн хүрээнд буюу нэр томьёонд хязгаарлагдмал байх ёстой (Мөнхцэцэг, 2021: 45) гэжээ. Ойролцоо утгатай нэр томьёо байх нь зохистой эсэх талаар судлаачид өөр өөр санал дэвшүүлсээр ирсэн байна.

Үг зүйн хувьд зөв хэлбэржсэн байх нь нэр томьёоны стандартын үндсэн шалгуур юм (<https://www.gov.wales/bydtermcymru>). Гэтэл НТСХ-т шуудангийн илгээмжийн төлбөрийг урьдчилан бүрэн төлөхийг *төлбөр төлөгдсөн*; шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталсан тэмдэгтийг *төлбөр хийгдсэн*; төлбөрийг бүрэн хийсэн илгээмжийг *зохих ёсоор төлбөр хийгдсэн* (MNS 0515: 2015) гэж тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржүүлэн нэр томьёо оноожээ. Эдгээр нь нэр томьёо *товч байх*⁴, *ганц утгатай байх*⁵, *оновтой байх*⁶, *тогтолцоотой байх*⁷ зэрэг шалгуурт үл нийцнэ. Учир нь *төлбөр төлөгдсөн*, *төлбөр хийгдсэн*, *зохих ёсоор төлбөр хийгдсэн* зэрэг нэр томьёогоор ямар ухагдахууныг илэрхийлж байгаа нь тодорхойгүй байна. Нэр томьёоны бүрэлдэхүүнд байгаа үгс тухайн ухагдахууны онцлог, шинж чанарыг илэрхийлж байх ёстой. Ялангуяа тухайн салбарын нэр томьёоны онцлогийг тусгах нь зүйтэй. *Төлбөр төлөгдсөн* гэдэг нь *duly prepaid; fully prepaid* (MNS 0515: 2015) хэмээх нэр томьёоны үгчилсэн орчуулга юм. Иймд шуудангийн илгээмжийн төлбөрийг урьдчилан бүрэн төлснийг *төлбөр төлсөн илгээмж* гэж оноох нь тохиромжтой. Түүнчлэн нэр томьёонд аль болох товч байх шаардлагыг тавьдаг бөгөөд нэг болон хоёр үг, гурван үгээс хэтрүүлэхгүйгээр нэг ухагдахуун илтгэсэн нэр томьёо зохиохыг чухалчилдаг. (Шагдарсүрэн ба бус, 2022: 105). *Зохих ёсоор төлбөр хийгдсэн* гэдэг нь *properly / fully prepaid* гэдгийн орчуулга бөгөөд ухагдахуун, нэрлэлтийн хувьд *төлбөр төлсөн илгээмж* гэдэгтэй адил байна.

⁴ Нэр томьёонд аль болох товч байх шаардлагыг тавьдаг бөгөөд нэг болон хоёр үг, гурван үгээс хэтрүүлэхгүйгээр нэг ухагдахуун илтгэсэн нэр томьёо зохиохыг чухалчилдаг. Энэ нь хэл шинжлэлийн үндэстэй бөгөөд олон үгтэй нэр томьёо дундын нэг утга илтгэх чанараа алддагтай холбоотой (Шагдарсүрэн ба бус, 2022: 105).

⁵ Үгийн сангийн үг ойролцоо, салаа утгатай байж болох боловч нэр томьёоны үүргээр хэрэглэгдэж буй үг зөвхөн ганц утгатай байх бөгөөд тухайн салбартаа нэгж ухагдахуун илтгэнэ (Шагдарсүрэн ба бус, 2022: 105).

⁶ Нэр томьёо нь тухайн ухагдахуунаа яв цав, бүрэн дүүрэн илэрхийлэх нь чухал байдаг тул цаад зүйлийнхээ шинж чанарыг нарийн ажиглаж нэр томьёо тогтоох нь чухал юм. Оновчгүй нэрлэлт хүний сэтгэхүйд хадгалагдан үлддэггүй тул солигдох, мартагдах, гадаад үгээр хэрэглэх зэрэг сөрөг талтай (Шагдарсүрэн ба бус, 2022: 105).

⁷ Нэр томьёо нь салангид үгсийн бөөгнөрөл биш бөгөөд тухайн шинжлэх ухааныхаа тогтолцоонд суурилсан шинжтэй байдаг. Нэр томьёо тогтоохдоо энэхүү тогтолцоот шинжийг алдагдуулахгүйгээр хэл зүйн ижил хэлбэр, үгийн сангийн ойролцоо үг зэргийг ашигладаг (Шагдарсүрэн ба бус, 2022: 105).

Иймд *төлбөр төлөгдсөн, зохих ёсоор төлбөр хийгдсэн* хэмээх ойролцоо утгатай нэр томьёог *төлбөр төлсөн илгээмж* гэж нийлэмж нэр томьёогоор оноох нь зохистой юм. Мөн *төлбөр хийгдсэн, төлбөрийн дардас* зэрэг нь ойролцоо утгатай байна. Учир нь төлбөр төлснийг илэрхийлэх тамга, дардас, тэмдэгтийг *төлбөрийн дардас*; шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталсан тэмдэгтийг *төлбөр хийгдсэн* (MNS 0515: 2015) гэжээ. Энэ нь нэг ухагдахууныг илэрхийлж байгаа бөгөөд *төлбөрийн дардас* гэж оноох нь тохиромжтой.

Түүнчлэн хүлээн авагч илгээмжээ шуудангийн салбараас ирж авах үйлчилгээг *өөрөө хүлээн авах*; шуудангийн салбараас хүлээн авагч өөрийн биеэр ирж авах илгээмжийг *өөрөө хүлээн авах илгээмж* (MNS 0515: 2015) хэмээн нэг ухагдахууныг илэрхийлсэн ойролцоо нэр томьёо буй. Энэ хоёр нэр томьёоны нэрлэлт, тодорхойлолт адилхан байгаа тул *өөрөө хүлээн авах илгээмж* хэмээн нэр томьёо оноовол зохистой. Мөн хүлээн авсан даруйдаа цааш нь дамжуулах, ялгалтад оруулах шууданг *давуу эрхтэй депеш*; хүлээн авсан даруйдаа цааш нь дамжуулах, ялгалтад оруулах шуудангийн илгээмжийг *давуу эрхтэй илгээмж* (MNS 0515: 2015) хэмээн нэг ухагдахууныг хувилбар болгон тэмдэглэжээ. Үүнийг *давуу эрхтэй илгээмж* гэж уугуул үгээр оноохыг илүүд үзэж байна.

HTCX-т хавар эрт соёолбол тэр жилдээ үрээ өгчхөөд үхдэг, оройтож соёолбол өсөлтийн аль ч шатандаа өвөлжиж чаддаг нэг наст хог ургамлыг *өвөлжигч хог ургамал*; хэдийд соёолсноос хамаарахгүйгээр өөрийн өсөлт хөгжилтдөө өвлийн бага температурыг шаарддаг учраас нэг өвлийн дараа үрээ өгдөг нэг наст хог ургамлыг *өвөлжих хог ургамал* (MNS 3472: 1983); ерөнхий ашиглалтын чиглэлээр эсвэл сэргээн ургуулах зорилгоор тухайн ойгоос тодорхой хэмжээний нас, хэмжээ, чанартай модыг сонгон, огтолж бэлтгэх аргыг *түүвэрлэх огтлол*; тодорхой хэмжээ, чанартай ойд болц гүйцсэн модыг ойгоос сорчлон огтлох огтлолтыг *түүвэрлэх огтлолт* (MNS 4118: 1991); зөвхөн үрээр үрждэг, хоёроос илүүгүй жил насалдаг, үр боловсорсны дараа үхдэг хог ургамлыг *нэг, хоёр наст хог ургамал*; үрээ өгөхдөө заавал хоёр жил шаарддаг хог ургамлыг *хоёр наст хог ургамал* (MNS 3472: 1983) хэмээн нэг ухагдахууныг илтгэсэн үнэмлэхүй ойролцоо утгатай нэр томьёо тохиолдоно. Эдгээрийг *өвөлжих хог ургамал, түүвэрлэх огтлол, хоёр наст хог ургамал* гэж оноох нь оновчтой. Монгол хэлний -гч дагавар нь эм хүйсийн утга: *цагаагч, хээгч, харагч*; дэс дугаар: *анхдагч, хоёрдогч*; ажил эрхэлсэн хүнийг: *сурагч, туслагч* илэрхийлсэн утгатай (Бадамдорж, 2001: 78). Иймд *өвөлжигч хог ургамал* гэвэл утгын хувьд тохиромжгүй, харин *өвөлжих хог ургамал* гэвэл тухайн ургамлыг тодотгосон утгатай болно. *Түүвэрлэх огтлол, түүвэрлэх огтлолт* зэрэг нэр томьёо нэг ухагдахууныг илэрхийлж байгаа бөгөөд огтлох үйлийн үр дүнг илэрхийлж байгаа тул *түүвэрлэх огтлол* гэж нэрлэвэл оновчтой. Нэр томьёоны стандартчилал болон нэр томьёо судлалд нэр томьёо аль болох товч, тодорхой байх шалгуур тавьдаг. (<https://www.gov.wales/bydtermcymru>). *Нэг, хоёр наст хог ургамал* гэсэн нэр томьёогоор зөвхөн үрээр үрждэг, хоёроос бага насалдаг, үр боловсорсны дараа үхдэг хог ургамал гэсэн ухагдахууныг илтгэж байна. Иймд *хоёр наст хог ургамал* гэж оноох нь илүү оновчтой.

НТСХ-т өгөгдсөн суурьтай харьцуулан авч үзэж байгаа гадаргуу ба хэвийлт, байршилтын хэвийлтүүдийн хамтарсан илрэлийн үр дүнд бий болсон хэвийлтийг *хэлбэрийн ба байршилтын нийлбэр хүлцэл (sum of tolerance of location)*; хэлбэр ба дүрсийн нийлбэр хэвийлтийн зөвшөөрөгдсөн утгаар хязгаарлагдсан хязгаарыг *хэлбэр байршилтын нийлбэр хүлцэл (sum of tolerance of location)* (MNS 3339: 1982) гэж оноожээ. Энэ нь нэг ухагдахууны илэрхийлж байгаа бөгөөд *хэлбэр, байршилтын нийлбэр хүлцэл* гэхэд бүрэн тохирох билээ.

Мөн *товчилсон нэр, товчилсон үг* хэмээх нэр томьёог авч үзье. НТСХ-т тухайн ойлголт (B.60)-ыг товч илэрхийлэхийн тулд олон үг, үсэг бүхий урт хэлбэрээс зарим үг, үсгийг нь хассан тэмдэглэгээ (B.132)-г *товчилсон үг (abbreviation)* хэмээн оноосон бол ТХТ /Техникийн хорооны төсөл/, ОУСТ /Олон улсын стандартын төсөл/, ОУСЭТ /Олон улсын стандартын эцсийн төсөл/... зэрэг товчилсон үгийг дурдан, *товчилсон нэр (abbreviated terms)* (MNS ISO/TS 19104: 2012) гэж оноожээ. Эдгээр нэр томьёоны англи нэрлэлтийг үзэхэд *abbreviation*-ийг *товчилсон үг, abbreviated terms*-ийг *товчилсон нэр томьёо* гэж оноох нь зохистой. Олон улсын стандартад ижил ухагдахууныг илэрхийлэх ба бүрэн хэлбэрээс хэсгийг нь оролцуулж бүтээсэн нэрлэлтийг *товчлол (abbreviation)* (ISO 1087: 2019(E)) гэсэн бий. Энэхүү товчлол нь бие даасан үгсийг хэрэглээнээс түрэн гаргадаггүй ба эмхэтгэл нэр томьёо, үсгээр товчилсон нэр томьёо, цомхотгол нэр томьёог хэлнэ (ISO 1087: 2019(E)).

Хэл шинжлэлд хэлний нэгж бүр ойролцоо байна гэж үздэг (Мөнгөнцэцэг, 2012: 89). Утга зохиолын хэл ойролцоо нэрээр баялаг байх нь түүний сайн, давуу талын нэг байдаг бол нэр томьёоны хүрээнд ойролцоо нэр олшрох нь тэр ухааны тогтолцоо цэгцрээгүй, төлөвшөөгүйг илтгэдэг (Адьяа, 2021: 61). Ийм зүйл НТСХ-т ажиглагдаж байна. Учир нь объектын ажиллах чадвар алдагдсан байдлыг *саатал*, объектын найдвартай ажиллах байдал алдагдсан үеийг *гэмтэл* (MNS 3831: 2003) гэжээ. Энэ нь нэг ухагдахууныг илтгэсэн *гэмтэл, саатал* хэмээх хувилбар нэр томьёо ажээ. Орчин цагийн монгол хэлнээ ямар нэг үйл бүтээхэд хүндрэл бэрхшээл гарч, ажил хэрэг удаашрахыг *саатал* (<https://mongoltoli.mn/dictionary/detail/74518>) гэдэг. Харин аливаа юмс эвдрэх, бэртэх, хэмхрэхийг *гэмтэл* (<https://mongoltoli.mn/dictionary/detail/27931>) гэнэ. Иймд объектын ажиллах чадвар алдагдсан байдлыг *саатал* гэж оноох нь зохистой юм. Түүнчлэн залгаатай барилгыг (3.1.3) тусгаарлах хана (5.1.7)-ыг *тусгаарлах хана, тусгаарлагч хана / separating wall* (MNS ISO 6701-1: 2010); өөр өөр оршин суугч ба байрны хоёр барилгыг (3.1.3) тусгаарлах хана (5.2.57)-ыг *хуваах хана, тусгаарлах хана / party wall* (MNS ISO 6701-1: 2010) гэжээ. Энэ нь залгаа баригдсан хоёр барилгыг салган тусгаарлагч хана гэсэн нэг ухагдахууныг илтгэж байгаа бөгөөд *тусгаарлах хана* гэж онооход бүрэн тохирох ажээ.

НТСХ-т шугам хоолой (3.2.32) буюу битүү нөөцлүүр саванд хүн орохыг зөвшөөрсөн, салгаж болох тагтай суурилуулсан нүх (5.3.1)-ийг *нээлхий, нүх, суваг* (MNS ISO 6701-1: 2010) гэж оноосон байна. Энэхүү нээлхийд (5.4.19) зориулсан

нэвтрэх таг (5.4.21)-ийг *нээлхийн таг, халив* (MNS ISO 6701-1: 2010) гэжээ. Мөн нөөцлүүр сав, хорго, гуу, хоолой (5.4.17) буюу үйлчилгээний техникийн орон зайд (4.4.11) нэвтрэхийг зөвшөөрөх салдаг буюу ихэвчлэн рамд (5.1.74) нугасаар бэхлэгдсэн хавтан (5.5.17)-г *нэвтрэх таг, халив* гэж нэрлэсэн бөгөөд эдгээр нь ойролцоо утгатай нэр томъёо юм. Энэ нь нэг ухагдахууныг илэрхийлсэн хувилбар нэр томъёо биш зэрэгцээ ухагдахууныг илэрхийлсэн ойролцоо нэр томъёо ажээ. Зэрэгцээ ухагдахуун гэдэг нь бусад дэд ухагдахууны адил *дэд ангиллын шалгуур*⁸-аар бүтсэн дэд ухагдахуун юм. (ISO 1087: 2019(E)). Мөн зэрэгцээ ухагдахууны дээд ухагдахуун нь *ижил байна* (ISO 1087: 2019(E)). Шугам хоолой (3.2.32) буюу битүү нөөцлүүр саванд хүн орохыг зөвшөөрсөн, салгаж болох тагтай суурилуулсан *нүх гэсэн утгатай нээлхий, нүх, суваг* гэдэг нь дээд ухагдахуун⁹ юм. Иймд *нэвтрэх таг, халив ~ нээлхийн таг, халив* зэрэг нь зэрэгцээ ухагдахууныг илэрхийлсэн ойролцоо утгатай нэр томъёо юм.

НТСХ-т нэг ба хоёр талдаа бүрээсэн өнгөлгөөтэй эсвэл нийлэг тор, төмөр тор, металл пүрш буюу тэдгээртэй ижил төстэй материалаар бүрсэн бүрээстэй, бүрээс нь дулаалгын материалтай механик холболттой зөөлөн чанарын дулаан тусгаарлах бүтээгдэхүүнийг *зулхай* (MNS ISO 9229: 2010); эмх замбараагүй утаслаг ширхэглэл бүхий бүтэцтэй, холбогчтой ба холбогчгүй эрдэс хөвөн болон хөвөнлөг шинж чанартай бусад материалуудыг *хөвөн / зулхай* (MNS ISO 9229: 2010) гэж тэмдэглэжээ. Зулахад бэлтгэн савж сэмлэсэн ноос хөвөн; үйлдвэрийн хөвсгөр нимгэн эсгийг *зулхай* (<https://mongoltoli.mn/dictionary/detail/49060>) гэдэг. Бүр нарийвчилбал, ямар нэг юмыг зайгүй тэгш эвлүүлэн тохируулж, эгнүүлж тавих гэсэн утгатай *зул* (Mo. *julu-*) хэмээх үйл язгуурын араас тэмдэг нэр бүтээх *-хай*³ (Mo. *qai*) дагавар залгаж бүтсэн бөгөөд эх эсгийн дээр дэвсэж тавьсан цагаан ноосны өөг дарж, өнгө алаглуулан оруулсан хялгасыг *зулхай* гэдэг. Монгол бичгийн болон ярианы хэлний зарим үгийг утга шилжүүлэн хэрэглэх нь нэр томъёо оноон тогтоох үндсэн зарчмын нэг (Догсүрэн, 1988: 12). Иймд эмх замбараагүй утаслаг ширхэглэл бүхий бүтэцтэй, холбогчтой ба холбогчгүй эрдэс хөвөн болон хөвөнлөг шинж чанартай бусад материалуудыг *хөвөн / зулхай* (MNS ISO 9229: 2010) гэж хувилбар нэр томъёогоор оноохоос илүүтэй *зулхай* хэмээх үгийг утга шилжүүлэн оноовол тохирох ажээ. Харин “нэг ба хоёр талдаа бүрээсэн өнгөлгөөтэй эсвэл нийлэг тор, төмөр тор, металл пүрш буюу тэдгээртэй ижил төстэй материалаар бүрсэн бүрээстэй, бүрээс нь дулаалгын материалтай механик холболттой зөөлөн чанарын дулаан тусгаарлах бүтээгдэхүүн”-ийг *хөвөн* гэж оноовол ухагдахууныг оновчтой илтгэнэ. Ерөнхий хэлний үг болон үгийн сангийн нэгж тусгай мэргэжлийн салбар юм уу судлагдахуунд нэр томъёоны үүргээр хэрэглэгдэж буй үйл явцыг *нэр томъёожих* (ISO 1087: 2019(E)) гэдэг.

⁸ Жишээ нь дэд ангиллын шалгуураар ‘хувцаслалт’ нь ‘гадуур хувцас’, ‘дотуур хувцас’ гэсэн тусгай ухагдахуун илэрхийлнэ. Эдгээр нь ‘хувцас’ хэмээх ерөнхий ухагдахууны харьцаан дахь зэрэгцээ ухагдахуун юм (1087:2019(E), 2019).

⁹ Жишээ нь ерөнхий харьцаанд ‘тавилга’ нь ‘сандаг’, ‘ширээ’ хоёрын дээд ухагдахуун; хэсгийн харьцаанд ‘мод’ нь ‘үндэс’, ‘мөчир’ хоёрын дээд ухагдахуун (1087:2019(E), 2019).

Түүнчлэн илэрхийлж буй ухагдахууны онцлогийг аль болох тусгахыг эрмэлзэх нь нэр томьёоны стандартчиллын үндсэн шалгуур юм (<https://www.gov.wales/bydtermcymru>). Иймд *хөвөн*, *зулхай* хэмээх үгсийн үгийн сангийн утга тухайн ухагдахууны онцлог шинжийг бүрэн илтгэнэ.

НТСХ-т өнгө татаагүй элдэж боловсруулсан хөрс нь цагаан ба будагтай нэхийгээр хийсэн хувцсыг *илгэн нэхий дээл* (MNS 3843: 1985); үсийг сайжруулан боловсруулж үсийг гадагш харуулан хийсэн, будагтай будаггүй нэхий хувцсыг *үслэг нэхий хувцас* (MNS 3843: 1985) гэж нийлэмж нэр томьёогоор нэрлэжээ. Энэ нь “*үстэй дээл, хувцас*” хэмээх дээд ухагдахуунд хамаарах зэрэгцээ ухагдахуун юм. Өнгө татаагүй элдэж боловсруулсан хөрс нь цагаан ба будагтай нэхийгээр хийсэн хувцсыг *илгэн нэхий дээл* гэж нийлэмж нэр томьёогоор оноохоос илүүтэй бидний өмнө дурдсан *заргаг*¹⁰ хэмээх нэр томьёогоор тэмдэглэвэл *зохистой*. *Заргаг* хэмээх үг орчин цагийн төв халх аялгуунд төдий л тохиолдохгүй харин ойрад аялгуунд өнгө татаагүй илгэн дээлийг *dzargāk* “*заргаг*”, *zargāk* “*заргаг*” (Цолоо, 1988: 239) гэдэг. Нутгийн олон аялгууны үгээс оновчтой заримыг авч хэрэглэх нь нэр томьёо оноон тогтоох үндсэн зарчмын нэг юм (Догсүрэн, 1988: 12). Түүнчлэн хүйтний улиралд үсийг нь гадагш харуулан өмсөх арьсан хувцсыг дах (<https://mongoltoli.mn/dictionary/detail/32620>) гэдэг. Иймд “*үслэг нэхий хувцас*” хэмээх нийлэмж нэр томьёогоор оноохоос илүүтэй дах хэмээх энгийн нэр томьёо (*simple term*)¹¹-оор оноох нь тохиромжтой. Олон улсын стандартад дэд ангиллын шалгуураар ‘хувцаслалт’ нь ‘гадуур хувцас’, ‘дотуур хувцас’ гэсэн тусгай ухагдахуун илэрхийлнэ. Эдгээр нь ‘хувцас’ хэмээх ерөнхий ухагдахууны харьцаан дахь зэрэгцээ ухагдахуун юм (ISO 1087: 2019(E)). Иймд *үстэй дээл, хувцас* хэмээх ерөнхий ухагдахууны харьцаан дахь зэрэгцээ ухагдахуун нь *заргаг, дах* хоёр юм. Нэр томьёонд аль болох товч байх шаардлагыг тавьдаг бөгөөд нэг болон хоёр үг, гурван үгээс хэтрүүлэхгүйгээр нэг ухагдахуун илтгэсэн нэр томьёо зохиохыг чухалчилдаг. Энэ нь хэл шинжлэлийн үндэстэй бөгөөд олон үгтэй нэр томьёо дундын нэг утга илтгэх чанараа алддагтай холбоотой (Шагдарсүрэн ба бус, 2022: 105). Иймд *илгэн нэхий дээл, үслэг нэхий хувцас* хэмээх нийлэмж нэр


¹⁰ Мал, амьтны зузаан арьсыг элдэн боловсруулж, арьсны илгэн талыг гадагш харуулж оёсон үстэй дээлийг *заргаг* гэдэг. Түүнчлэн

Залуу нас замд элдэг

Заргаг дээл эгэмд элдэг гэсэн хэлц үг бий. Монголын нууц товчоо-ны §114: *uduyit-merkit dürberün buluqan taqalaitu maral-un godun qudusutu ilkin jarqaq usun-u buluqan jalqaqsan de'eltü tabun nasutu kücü neretü nidüu-dür-iyen qaltu kö'üken-i bidan-u ceri'üt nuntuq-tur qocoriqsan-i olju abciraju hö'elün-eke-de sauqa abcu otcu ökba* (Rachewiltz, 1972: 47) *Удүйд Мэргидийг дүрвэрүүн (дүрвэх үед) булган малгайт, марлын годон гутуст (гуталт) илгэн жархаг усны булга залгасан дээлт таван наст Хүчү нэрт нүдэндээ галт хөвүүхнийг бидний цэргүүд нутагт хоцорсныг олж авчирч, Өгээлүн эхэд сауха авч одож өгөв* (Чоймаа, 2011: 65) хэмээн *jarqaq* “жархаг” гэсэн хэлбэрээр тохиолддог. Тус үгийг Ш.Чоймаа эртний түрэгээр үсийг нь халцлан боловсруулсан арьс буюу илэг (Чоймаа, 2011: 65) гэж тайлбарлажээ. Мөн эртний түрэг хэлнээ *жаргақ, йаргақ* (Севортян, 1989: 20) гэж буй. Сэцэнцогт үсийг нь хуссан зөөлөн арьс, илэг гэж тайлбарлан, уйгур *jaɣaq*, түрэг *ɟaɣaq* (Сэцэнцогт, 1981: 2353) хэлний баримттай харьцуулан тайлбарлажээ. Иймд *заргаг дээл* хэмээн тэмдэглэж, хуучин үгийг нэр томьёоны үүргээр ашиглавал *зохистой* (Гэндэнпил, 2023: 30).

¹¹ дан үг юм уу үгийн сангийн нэгжээс бүрдсэн энгийн нэр томьёо (ISO 1087: 2019)

томъёотой харьцуулахад *заргаг*, *дах* хэмээх үгийн сангийн нэгж ухагдахууныг товч, оновчтой илтгэнэ. *Заргаг*¹², *дах*¹³ хэмээх үгээр жишээлэн, ойролцоо утга илэрхийлж буй зэрэгцээ ухагдахууныг загварчлан үзүүлбэ.



Зураг 2. НТСХ-ийн ойролцоо утгатай нэр томъёо

“Хэлний ямарваа хоёр элементийн нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдох шинжийг нөхөх байрлал (дополнительная дистрибуция-complementary distribution) мөн ямарваа хоёр элементийн нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдох шинжийг үл нөхөх байрлал (контрастирующая дистрибуция-contrastive distribution) гэж ялган нэрлэж байна. Өөрөөр хэлбэл, хэлний нөхөх байрлалд тохиолдох хоёр элемент нь нэг нэгжийн утга үл ялгах хоёр хувилбар байж, үл нөхөх байрлалд тохиолдох хоёр элемент нь тус тусдаа утга ялгах биеэ даасан хоёр нэгж байна гэсэн үг болно” (Лувсанвандан, 2019: 107). Ойролцоо утгатай үгийг үгийн сангийн ойролцоо утгат үг, үнэмлэхүй ойролцоо утгат үг, найруулгын ялгаат ойролцоо утгат үг, хэлэхүйн буюу хам сэдвийн ойролцоо утгат үг (Шагдарсүрэн ба бус, 2022: 161) гэж дөрөв ангилдаг. Хэлний хэрэглээнд ойролцоо утгатай үг нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолддог тул үл нөхөх байрлалд хамаарна. Нэр томъёо судлалд зэрэгцээ ухагдахууныг ялган илэрхийлж байгаа тул ойролцоо утгатай нэр томъёо нөхөх байрлалд хамаарна. Учир нь хоёр элементийн нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдох бөгөөд тухай тухайн ухагдахууныг ялган тодорхойлно гэсэн үг юм. Иймд *нэвтрэх таг*, *халив* ~ *нээлхийн таг*, *халив*; *заргаг* ~ *дах*; *хөвөн* ~ *зулхай* зэрэг ойролцоо утгатай нэр томъёо нь зэрэгцээ ухагдахууныг ялган тодорхойлж байгаа тул нэг нь нөгөөгийнхөө байранд үл тохиолдоно.

¹² Монгол Улсын хөдөлмөрийн баатар Б.Лувсан 1942 онд 19 настайдаа Бийск хотноо Бэлэг хүргэж явахдаа аахуулсан зураг. Гэрэл зургийг Соёлын Өвийн Үндэсний Төвийн зөвлөх, доктор (Ph.D), профессор М.Ганболдоос авав.

¹³ Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын буриад иргэн С.Чулуун. 2015.11.11. Гэрэл зургийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Батцэцэогийн авав.

Харин НТСХ-т *өөрөө хүлээн авах ~ өөрөө хүлээн авах илгээмж; давуу эрхтэй депеш ~ давуу эрхтэй илгээмж; саатал ~ гэмтэл; товчилсон нэр ~ товчилсон үг; тусгаарлах хана, тусгаарлагч хана ~ хуваах хана, тусгаарлах хана; нэг, хоёр наст хог ургамал ~ хоёр наст хог ургамал; өвөлжигч хог ургамал ~ өвөлжих хог ургамал; түүвэрлэх огтлол ~ түүвэрлэх огтлолт* зэрэг нэр томьёо нэг ухагдахууныг илтгэжээ. Нэр томьёоны олон улсын стандартад “*term variation*” гэж тэмдэглэн, нэг хэлэн дэх ижил ухагдахууныг тэмдэглэсэн нэр томьёо (ISO 860: 2007) гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл нэг ухагдахууныг нэг хэлэнд хоёроос дээш нэр томьёогоор илэрхийлбэл хувилбар нэр томьёо болно. Дурдсан / *өөрөө хүлээн авах ~ өөрөө хүлээн авах илгээмж; нэг, хоёр наст хог ургамал ~ хоёр наст хог ургамал* г.м/ нэр томьёогоор нэг л ухагдахууныг илэрхийлж байгаа тул ойролцоо нэр томьёо биш хувилбар нэр томьёо юм.

5. Дүгнэлт

Нэр томьёог тусгай стандартад нийцүүлэн батлах үйл явцыг нэр томьёоны стандартчилал гэнэ. Нэр томьёоны стандарт нь стандартын үндсэн шалгуурт нийцсэн байх ёстой. Бид хэрэглэгдэхүүн болгон авсан хөмрөгт буй нийлэмж нэр томьёог бүтэц, нэрлэлтийн үүднээс задлан шинжлэв.

НТСХ дэх тодотгох үүргээр хэрэглэж буй *шураг (н) уллагаатай гутал, зээрэнцэг (н) хутгатай зоргодослох суурь машин, тээг (н) холбоос, нүүр (н) хэсэг, нунтаг (н) гал унтраагуур, цагариг (н) шатаагуур* зэрэг нь нийлмэл үгийн бүтцийн хувьд буруу хэлбэржсэн нэр томьёо юм. Энэ нь зөвхөн нийлэмж нэр томьёоны бүтцэд тохиолдохгүй орчин цагийн монгол хэлний нийлмэл үгийн бүтцэд ч ажиглагдаж байна. Гэхдээ үг зүйн хувьд буруу хэлбэржсэн нэр томьёог зүйд нийцүүлэх нь нэр томьёоны стандартчиллын үндсэн ажил билээ.

Түүнчлэн ойролцоо утгатай нэр томьёо байх нь зохистой эсэх талаар судлаачид өөр өөр санал дэвшүүлсээр иржээ. Харин бид ерөнхий ухагдахууны харьцаан дахь зэрэгцээ ухагдахууныг илэрхийлсэн ойролцоо утгатай нэр томьёо байх нь зохистой гэж үзэв. Учир нь НТСХ дэх *нэвтрэх таг, халив ~ нээлхийн таг, халив; заргаг ~ дах; хөвөн ~ зулхай* зэрэг нэр томьёо нь зэрэгцээ ухагдахууныг илэрхийлж буй ойролцоо утгатай нэр томьёо юм. Мөн *илгэн нэхий дээл, үслэг нэхий хувцас* хэмээх нийлэмж нэр томьёог *заргаг, дах* хэмээх энгийн үгээр оноовол ухагдахууныг товч, оновчтой илтгэнэ.

Ухагдахууныг тодорхойлж, нэр томьёог жигдлэх нь нэр томьёоны стандартын үндсэн шалгуур юм. Нэрлэлтийн хувьд ойролцоо мэт боловч ухагдахуун, нэр томьёоны тодорхойлолтоос үзэхэд нэг ухагдахууныг давтан илэрхийлсэн хувилбар нэр томьёо олон байна. Үүнийг бид НТСХ-ийн нэр томьёо, тодорхойлолтоор жишээлэн, ухагдахууныг зөв тодорхойлсон, үг зүйн хувьд зөв хэлбэржсэн нэр томьёог стандартчилах нь тохиромжтой гэж үзэв.

Ном зүй

- Brund de Besse, Blaise Nkwenti-Azeh Juan C Sager.** (1997). *Glossary of Terms Used in Terminology*. Manchester: John Benjamins Publishing company.
- Keith Brown., Jim Miller.** (2013). *The Cambridge Dictionary of Linguistics*. Cambridge: University Printing House.
- Saeed John I.** (2009). *Semantics*. Singapore: Utopia Press.
- Адьяа, О.** (2021). Нэр томъёог оноон тогтоох үндсэн зарчим, арга хэлбэр. *Монгол нэр томъёо судлал: уламжлал, шинэчлэл*, 60-65. [Basic Principle, Method and Format for Creating Terms]. *Mongol ner tomiyo sudlal: ulamjlal, shinechlel*, 2021, 60-65.]
- Бадамдорж, Д.** (2001). *Монгол хэлний утга судлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Badamdorj, D. *Mongol helnii utga sudlal* [Mongolian Semantics]. Ulaanbaatar: Münkhiin üseg. 2023.]
- Гэндэнпил, Х.** (2023). Хуучин үгийг нэр томъёоны үүргээр хэрэглэх нь. *Хэрэглээний хэл шинжлэл VIII*, 26-38. [Using Archaic Word As Terminology]. *Applied Linguistics VIII*, 26-38.]
- Гэрэлмаа, Г.** (2020). *Монгол хэлний нэр томъёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G. *Mongol helnii ner tomiyo бүтэх нийлэг болон задлаг хэв шинж* [Analythic and Synthetic Methods of Creating Terms in Mongolian]. Ulaanbaatar: Soyombo Printing.]
- Догсүрэн, Ч.** (1988). *Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр. [Dogsüren, Ch. *Mongol ner tomiyo оноох, толилох, жигдлэх асуудалд* [On the Issues of Creating, Processing, Harmonizing Mongolian Terms]. Ulaanbaatar: Printing of Mongolian Academia of Science. 1988.]
- Лувсанвандан, Ш.** (2019). Хэлний нөхөх, үл нөхөх байрлалын тухай асуудалд. *Хэл шинжлэлийн онолын асуудлууд*, 102-110. [Contribution to the Complementary and Noncomplementary Distribution in Language. *Hel шинжлэлийн онолын асуудлууд*, 2019, 102-110.]
- Мөнгөнцэцэг, Б.** (2012). *Монгол хэлний ойролцоо зэргэд*. Улаанбаатар: Битпресс. [Müngüntsetseg, B. *Mongol helnii ойролцоо зэргэд* [Parallelism Synonym in Mongolian Language]. Ulaanbaatar: Bit Press. 2012.]
- Мөнхцэцэг, Н.** (2021). Хуулийн ойролцоо утгатай зарим нэр томъёоны асуудалд. *Хэрэглээний хэл шинжлэл VI*, 40-58. [On Issues of Some Synonym Terms in Laws. *Applied Linguistics VI*, 40-58.]
- Мөнхцэцэг, Н., Мөнх-Учрал, Э., Эрдэнэ-Очир, Т.** (2022). *Хэрэглээний хэл шинжлэл, хэл боловсруулалт, түгээмэл хэл зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Münkhtsetseg, N., Mönkh-Uchral, E., Erdene-Ochir, T. *Heregleenii hel шинжлэл, хэл боловсруулалт, түгээмэл хэл зүй* [Applied Linguistics, Natural Language Processing, Universal Grammar]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2022.]
- Өнөрбаян, Ц.** (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй. [Önörbayan, Ts. *Orchin tsagyn mongol helnii үг зүй* [Modern Mongolian Morphology]. Ulaanbaatar: 2004.]
- Пүрэвжав, Э., Ганболд, Д., Заяабаатар, Д., Энхжаргал, С., Эрдэнэтуяа, П., Баттогтох, Г.** *Бичгийн хэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Pürevjav, E., Ganbold, D.,

Zayabaatar, D., Enkhjargal, S., Erdenetuya, P., Battogtokh, G. *Bichgiin hel* [Written Language]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2022.]

Соронзон, Д. (2021). *Монгол бичиг: үгийн бүтэц, дүрэм, дасгал, тайлбар*. Улаанбаатар: Арвай бархан. [Soronzon, D. *Mongol bichig: ügiin бүтэц, дүрэм, dasgal, тайлбар* [Mongolian Script: Word Structure, Rules, Exercises, Explanations]. Ulaanbaatar: Arwai Barkhan. 2021.]

Цолоо, Ж. (1988). *БНМАУ дахь нутгийн аялгууны толь бичиг II*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. [Tsoloo, J. *BNMAU dahi nutgiin ayalguunii toli bichig II* [Dictionary of Dialect in the Mongolian People's Republic]. Ulaanbaatar: Committee for State Trades Assair. 1988.]

Шагдарсүрэн, Ц., Бадамдорж, Д., Самбуудорж, О., Пүрэвжав, Э., Баттөгс, Ш., Гэрэлмаа, Г. (2022). *Үгийн сан, утга зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Shagdarsüren, Ts., Badamdorj, D., Sambuudorj, O., Pürevjav, E., Battügs, Sh., Gerelmaa, G. *Ügiin san, utga zүй*] Lexicology, Semantics]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2022.]


ISO 1087: 2019(E). *Terminology Work and Terminology Science - Vocabulary*. Switzerland.

Хавсралт

Д/д	Стандарт	Салбар	Ойролцоо нэр томьёо	Тодорхойлолт
1	MNS 3843: 1985	Нэхий эдлэл ба түүний эд ангийн нэр томьёо	а) илгэн нэхий дээл b) үслэг нэхий хувцас	а) өнгө татаагүй элдэж боловсруулсан хөрс нь цагаан ба будагтай нэхийгээр хийсэн хувцас; b) үсийг сайжруулан боловсруулж үсийг гадагш харуулан хийсэн, будагтай будаггүй нэхий хувцас;
	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	а) төлбөр төлөгдсөн b) төлбөр хийгдсэн c) төлбөрийн дардас d) зохих ёсоор төлбөр хийгдсэн	а) шуудангийн илгээмжийн төлбөрийг урьдчилан бүрэн төлөх; b) шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталсан тэмдэгт; c) төлбөр төлснийг илэрхийлэх тамга, дардас, тэмдэгт; d) төлбөрийг бүрэн хийсэн илгээмж;
	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	а) өөрөө хүлээн авах b) өөрөө хүлээн авах илгээмж	а) хүлээн авагч илгээмжээ шуудангийн салбараас ирж авах үйлчилгээ; b) шуудангийн салбараас хүлээн авагч өөрийн биеэр ирж авах илгээмж;

	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томъёо	a) давуу эрхтэй депеш b) давуу эрхтэй илгээмж	a) хүлээн авсан даруйдаа цааш нь дамжуулах, ялгалтад оруулах шуудан; b) хүлээн авсан даруйдаа цааш нь дамжуулах, ялгалтад оруулах шуудангийн илгээмж;
			a) газрын шуудан b) газрын шуудан/ депеш	a) газраар болон далайгаар тээвэрлэгдэх, мөн ангилал буурсан агаарын (s.a.l) шуудан; b) хуурай газраар болон далайгаар тээвэрлэгдэх шуудан;
	MNS ISO 9229: 2010	Дулаан тусгаарлах материал	a) зулхай b) хөвөн /зулхай/	a) нэг ба хоёр талдаа бүрээсэн өнгөлгөөтэй эсвэл нийлэг тор, төмөр тор, металл пүрш буюу тэдгээртэй ижил төстэй материалаар бүрэн бүрээстэй, бүрээс нь дулаалгын материалтай механик холболттой зөөлөн чанарын дулаан тусгаарлах бүтээгдэхүүн; b) эмх замбараагүй утаслаг ширхэглэл бүхий бүтэцтэй, холбогчтой ба холбогчгүй эрдэс хөвөн болон хөвөнлөг шинж чанартай бусад материалууд
	MNS 3831: 2003	Техникийн найдвартай ажиллагаа	a) саатал b) гэмтэл	a) объектын ажиллах чадвар нь алдагдсан байдал; b) объектын найдвартай ажиллах байдал нь алдагдсан үе;
	MNS ISO/TS 19104: 2012	Газар зүйн мэдээлэл. Мэдээллийн технологи албан ажлын техник хэрэгсэл	a) товчилсон нэр b) товилсон үг	b) тухайн ойлголт (b.60)-ыг товч илэрхийлэхийн тулд олон үг, үсэг бүхий урт хэлбэрээс зарим үг, үсгийг нь хассан тэмдэглэгээ (b.132) [iso 1087- 1:2000]
	MNS ISO 6701-1:2010	Барилга ба иргэний барилга байгууламж	a) тусгаарлах хана, тусгаарлагч хана / separating wall b) хуваах хана, тусгаарлах хана / party wall	a) залгаатай барилгыг (3.1.3) тусгаарлах хана (5.1.7) b) өөр өөр оршин суугч ба байрны хоёр барилгыг (3.1.3) тусгаарлах хана (5.2.57)

	MNS ISO 6701-1:2010	Барилга ба иргэний барилга байгууламж	а) нэвтрэх таг, халив b) нээлхийн таг, халив	а) нөөцлүүр сав, хорго, гуу, хоолой (5.4.17) буюу үйлчилгээний техникийн орон зайд (4.4.11) нэвтрэхийг зөвшөөрөх салдаг буюу ихэвчлэн рамд (5.1.74) нугасаар бэхлэгдсэн хавтан (5.5.17) b) нээлхийд (5.4.19) зориулсан нэвтрэх таг (5.4.21)
	MNS 3472: 1983	Газар тариалан	а) нэг, хоёр наст хог ургамал b) хоёр наст хог ургамал	а) зөвхөн үрээр үрждэг, хоёроос илүүгүй жил насалдаг, үр боловсорсны дараа үхдэг хог ургамал; b) үрээ өгөхдөө заавал хоёр жил шаарддаг хог ургамал;
	MNS 3472: 1983	Газар тариалан	а) өвөлжигч хог ургамал b) өвөлжих хог ургамал	а) хавар эрт соёолбол тэр жилдээ үрээ өгч үхдэг, оройтож соёолбол өсөлтийн аль ч шатандаа өвөлжиж чаддаг нэг наст хог ургамал; b) хэдийд соёолсноос хамаарахгүйгээр өөрийн өсөлт хөгжилтдөө өвлийн бага температурыг шаарддаг учраас нэг өвлийг өнгөрөөсний дараа үрээ өгдөг нэг наст хог ургамал;
	MNS 4118: 1991	Хөдөө аж ахуй. Ойн аж ахуй	а) түүвэрлэх огтлол b) түүвэрлэх огтлолт	а) ерөнхий ашиглалтын чиглэлээр эсвэл сэргээн ургуулах зорилгоор тухайн ойгоос тодорхой хэмжээний нас, хэмжээ, чанартай модыг сонгон, огтолж бэлтгэх арга; b) тодорхой хэмжээ, чанартай ойд болц гүйцсэн модыг ойгоос сорчлон огтлох огтлолт



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.